



Монголын Үндэсний
Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН 2017



АГУУЛГА

Өмнөх үг

1. 2017 оны онцлох үйл явдал, арга хэмжээ
2. Гишүүнчлэл
3. Бодлогын өмгөөлөл
4. Хамтын ажиллагаа
5. Судалгаа
6. Арга хэмжээ
7. Үзэсгэлэн
8. Сургалт
9. Үйлчилгээ
10. Төсөл хөтөлбөр



ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

- Стратегийн зорилго 1:** Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх
- Стратегийн зорилго 2:** Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах
- Стратегийн зорилго 3:** Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах
- Стратегийн зорилго 4:** Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх
- Стратегийн зорилго 5:** Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах
- Стратегийн зорилго 6:** Танхимын засаглал, менежементийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх

ӨМНӨХ ҮГ

Юуны өмнө эдийн засгийн хямрал үргэлжилсэн энэ хүндхэн жилүүдэд бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлж хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэн, ажлын байраа хадгалан улсын төсөвт татвараа төлөх үүргээ нэр төртэй биелүүлэн Монгол улсын эдийн засагт өөрсдийн хувь нэмрийг оруулж байгаа нийт гишүүд, бизнес эрхлэгчиддээ талархлаа илэрхийлье.

2017 онд МҮХАҮТ нь эдийн засгийн хямралаас гарах, бодлого боловсруулагч шийдвэр гаргагчдын тооцоо судалгаагүй гаргасан шийдвэрээс үүдсэн алдаа завхралыг засах чиглэлээр илүү анхаарал тавьж 30 гаруй бодлогын баримт бичиг, хуулийн төслүүдэд санал өгч эргэх холбоотой ажиллалаа. Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагааны 100 хоногоо дүгнэж, энэ үеэр ОУВС-тай ахин хэлэлцээр хийж, бизнес эрхлэгчид ба иргэдийн саналыг хүлээн авч, ХАОАТ-ын нэмэгдлийг хүчингүй болгох, Онцгой албан татварыг тэглэх зэрэг бизнес, хөрөнгө оруулалтын орчинд эерэг нөлөө үзүүлэх шийдвэр гаргасан нь МҮХАҮТ-аас хүргүүлсэн мэдэгдлийн нэг үр дүн гэж үзэж байна. Мөн бодлогын өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагааг үндэслэлтэй, оновчтой явуулахын тулд үндэсний хэмжээний “Бизнесийн орчны судалгаа” ба “Монгол улсын татварын тогтолцооны шинэчлэл, татварын оновчлол” судалгааг шинээр хийж танилцууллаа.

Түүнчлэн өнгөрсөн онд бүс нутгийн болон хөрш орнуудын бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр санал санаачилга гарган, Монгол, Орос, Хятадын худалдаа эдийн засгийн 13-р дээд хэмжээний уулзалт ба Монгол-Хятадын 2-р экспо зэрэг томоохон арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Нийслэл, аймаг, дүүргүүдийн түвшинд бизнесийг дэмжих, ялангуяа бичил жижиг бизнест дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар үйл ажиллагаагаа идэвхжүүлэн “Chamber bus” ба “Entrepreneurship challenge” зэрэг хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүллээ.

Танхимын гишүүдэд үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, гишүүдийн сэтгэл ханамжийг сайжруулах чиглэлээр Олон улсын худалдааны төв, Олон улсын худалдааны танхим, Европын холбоо, ХБНГУ болон бусад орнуудын экспертүүдтэй хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, үйл явцуудаа тодорхойлон, стратегийн зорилтууд-нэгжийн зорилтууд-ажилтны зорилтууд гэсэн гүйцэтгэлийн хэмжигдэхүйц тогтолцоог бүрэн бүрдүүллээ.

Танхимаас 2018 оныг “Бизнесийн тогтвортой орчныг дэмжих жил” болгон зарлаж байгаа бөгөөд энэ хүрээнд хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагч болон нийгмийн



халамжид чиглэсэн төсвийн зарцуулалтыг багасгах, аливаа салбарыг дэмжсэн өгөөж, үр ашиг муутай элдэв сан, хөтөлбөрийг цөөрүүлэх, цэгцлэх, төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлээс бараа, үйлчилгээ нийлүүлэх эрх зүйн орчныг улам сайжруулах, бизнес эрхлэгчдийг татварын хураалтад тэгш, шударга хамруулж, татварын суурийг нэмэгдүүлэх, өрсөлдөөний шударга орчныг бий болгох чиглэлээр УИХ, Засгийн газар болон гишүүд, нийт бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах болно.

**МҮХАҮТ-ЫН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ЛХАГВАЖАВ**





1 2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, АРГА ХЭМЖЭЭ



Төсвийн тодотголын асуудлаар хийсэн мэдэгдэл, хэвлэлийн бага хурал, УИХ-ын дарга М.Энхболдтой хийсэн уулзалт

Засгийн газар Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т нэгдэх шийдвэр гаргаж, хөтөлбөрийн нөхцөлийг хангахын тулд татвар нэмэгдүүлсэн Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголыг УИХ-д өргөн барьсантай холбогдуулан МҮХАҮТ-аас мэдэгдэл гаргасан.

Мэдэгдэлд дурдсан асуудлаар танхимын удирдлагууд, УЗ-ийн төлөөлөл 2017 оны дөрөвдүгээр сард УИХ-ын дарга М.Энхболдтой уулзаж төсөв, санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулах, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг таатай болгох, үйлдвэрлэгчдэд хууль эрх зүйн болон бодлогын дэмжлэг үзүүлэх, татвар нэмэхгүйгээр татварын суурийг тэлэхэд анхаарах, төрийг цомхон, чадварлаг болгох, төрийн менежементийг сайжруулах, төсвийн зардлыг нэмэхгүй байх, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг нэн яаралтай хувьчлах зэрэг 8 зүйлийн шаардлага, хүсэлт тавьж тодорхой хэмжээнд шийдвэрлүүлсэн.



Эдийн засгийн бодлогын зөвлөл

Бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төр засагт хүргэх, тогтвортой хамтын ажиллагааг бий болгох зорилгоор Танхимын дэргэд Монголын тэргүүлэх эдийн засагчдаас бүрдсэн “Эдийн засгийн бодлогын зөвлөл” -ийг 11-р сард байгуулсан. Эдийн засгийн бодлогын зөвлөлөөс Төв банкны тухай болон Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналуудаа нэгтгэн боловсруулж УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлсэн.



МҮХАҮТ-ын тэргүүлэгчид, удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөлөл Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгатай хийсэн уулзалт

МҮХАҮТ-ын удирдлагууд, УЗ-ийн гишүүдийн төлөөллүүд МУ-ын Ерөнхийлөгч Х.Баттулгатай уулзаж бизнесийн орчны талаар саналаа солилцсон.

1 2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, АРГА ХЭМЖЭЭ



Монгол, Орос, Хятадын худалдаа, эдийн засгийн 13-р дээд хэмжээний уулзалт

Монгол, Орос, Хятадын худалдаа, эдийн засгийн 13-р дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээнд анх удаа ОХУ, БНХАУ-ын худалдааны танхимуудын дээд удирдлагууд оролцлоо. Дээд хэмжээний уулзалын нэгдсэн хэлэлцүүлэгт гурван улсын бүс нутгийн худалдаа, аж үйлдвэрийн танхим, бизнес эрхлэгчдийн 350 гаруй төлөөлөл цуглан, бүс нутгийн онцлог, нөөц боломжтой танилцаж, гурван улсын хил худалдаа, хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцсэн.



Монгол-Хятадын 2-р экспо

Монгол-Хятадын II Экспо арга хэмжээг 383 ААН, 734 бизнес эрхлэгчдийг хамруулан амжилттайгаар зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд оролцсон ААН-үүд нийт 6.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.





Олон Улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн сорилт (IWEC) байгууллагын 10-р их хурал

11-р сарын 12-14-нд АНУ-ын Вашингтон мужид болсон Олон Улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн сорилт (IWEC) байгууллагын 10 дугаар их хуралд Монголоос МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг тэргүүтэй төлөөлөгчид оролцож монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүд “IWEC-Awards” буюу амжилттай бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн олон улсын шагналыг хүртсэн.



2 ГИШҮҮНЧЛЭЛ


2017 онд МҮХАҮТ-ын нийт гишүүдийн тоо **3283** болсон. Үүнээс орон нутгийн гишүүн байгууллагын тоо **2153**, Улаанбаатар хотын гишүүдийн тоо **165**-аар нэмэгдэж **1130** байна.



2 ГИШҮҮНЧЛЭЛ

Салбар танхимын гишүүдийн тоо

№	Салбар Танхим	2017 гишүүн
1.	Архангай	54
2.	Баян-Өлгий	20
3.	Баянхонгор	65
4.	Булган	80
5.	Говь-Алтай	68
6.	Говьсүмбэр	66
7.	Дархан-Уул	279
8.	Дорнод	172
9.	Дорноговь	0
10.	Дундговь	127
11.	Завхан	74
12.	Орхон	200
13.	Өвөрхангай	171
14.	Өмнөговь	115
15.	Сүхбаатар	80
16.	Сэлэнгэ	69
17.	Төв	126
18.	Увс	124
19.	Ховд	95
20.	Хөвсгөл	180
21.	Хэнтий	101
	Нийт	2266




Шинэ гишүүдийн үйл ажиллагаатай танилцах аян

Танхимд гишүүн байгууллагаар элсээд нэг жил болж буй 48 аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцах аянаар танхимын удирдлага, газрын дарга нар, мэргэжилтнүүдийн хамтаар зочлон танхимын бүтээгдэхүүн үйлчилгээний тухай болон бизнест тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцон, саналуудыг холбогдох газруудад хүргэн ажилласан.



3 БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

2017 онд нийт **14** бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд **16** хуулийн төсөлд санал өгсөн. **13** хэлэлцүүлэг зохион байгуулж, **2** мэдэгдэл гарган, нийт **78** хороо, зөвлөл, комисст гишүүнээр ажиллаж байна.



Санал өгсөн хуулийн төсөл

1. ААНОАТ тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төсөл
3. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
4. ЖДҮ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
5. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн төсөл
6. Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журмын төсөл
7. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл
8. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
9. Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл
10. Өмгөөллийн тухай хуулийн төсөл
11. Гаалийн тухай хуульд шинэчилсэн өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
12. Худалдааны тухай хуулийн төсөл
13. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл
14. Банкны тухай хуулийн төсөл
15. Татварын багц хуулийн төсөл
16. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль



3 БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

Бодлогын баримт бичиг, журам

1. Органик хүнсний тухай хуулийг дагаж гарах 5 журмын төсөл
2. Байгальд ээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тухай журмын төсөл
3. “Эрчим хүч хэмнэлтийн үндэсний хөтөлбөр”
4. “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр 2016-2020” хөтөлбөр
5. Хуулийг дагаж гарах хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам
6. Газар тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам
7. Мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журам
8. Органик хүнсийг үйлдвэрлэхэд баримтлах журам
9. Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, түүнийг хэрэглэх журам
10. Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулах журам
11. Хуульчдын холбооны дүрэм
12. Хөрөнгө оруулагчдын төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэхийг тухай журам
13. “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ 2020” дэд хөтөлбөр
14. Эрчим хүч хэмнэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэлэлцүүлэг, уулзалт

1. “Эрчим хүчний хэрэглээний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих” журмын төслийн хэлэлцүүлэг
2. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг
3. Байгальд ээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тухай журмын хэлэлцүүлэг
4. УИХ-аар Төсвийн тодотгол хэлэлцэхтэй холбоотойгоор хэлэлцүүлэг
5. “Арбитрын ажиллагаан дах шүүхийн оролцоо” сэдвээр хэлэлцүүлэг
6. ЗГХЭГ-ын дэргэдэх Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлөөс “Хөрөнгө оруулагчдын төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэхийг тухай журам”-ын төслийн хэлэлцүүлэг
7. “Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг боловсруулахад танхим дээр тус журмын хэлэлцүүлэг
8. “Эрчим хүчний хэрэглээний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төслийн хэлэлцүүлэг
9. НЗДТГ-тай хамтран Утааны эсрэг хэлэлцүүлэг
10. ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь хэлэлцүүлэг
11. Зөрчлийн тухай хуулийн хэлэлцүүлэг
12. Татварын багц хуулийн төсөл боловсруулахтай холбоотой Татварын орчны хэлэлцүүлэг
13. “Үндэсний инновацийн шагналын журмын төсөл, Инновацийн төслийг бүртгэх, хэрэгжүүлэх журмын төсөл, Инновацийн төсөлд грант олгох журам” -д санал өгөх нээлттэй хэлэлцүүлэг





3 БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

МҮХАҮТ-аас төлөөлөн оролцдог хороо, зөвлөл, ажлын хэсгийн жагсаалт

Олон улсын байгууллага дахь танхимын төлөөлөл

1. Дэлхийн танхимуудын холбооны ерөнхий зөвлөлийн гишүүн
2. Ази номхон далайн танхимуудын холбооны дэд ерөнхийлөгч
3. Торгоны замын Олон улсын худалдааны танхимын дэд дарга

МҮХАҮТ-аас 2017 онд нийт 42 хороо, зөвлөл, комисст гишүүнээр төлөөлөн орж, хууль болон бодлогын бичиг баримт боловсруулах 33 ажлын хэсэгт орж саналаа илэрхийлэн дуу хоолойгоо хүргэж байна.

1. Эдийн засгийн бодлогын зөвлөл, ЗГХЭГ
2. Тогтвортой хөгжлийн үндэсний хороо, ЗГХЭГ
3. АНУ-ын Мянганы Сорилтын Корпораци (МСК)-тай байгуулах хоёр дахь компакт гэрээ боловсруулж, хэлэлцээ хийх ажлыг удирдлага, чиглэлээр хангах ажлын хэсэг, ЗГХЭГ
4. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл
5. Монгол улсын Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөл, ЗГХЭГ
6. Гаалийн тарифын зөвлөл, СЯ
7. Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн удирдах хороо, ХНХЯ
8. Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үндэсний Зөвлөл
9. Монгол банкны Хяналтын зөвлөл
10. Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн удирдах зөвлөл
11. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэдэх Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны дэд дарга, ЗГХЭГ
12. Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг бэлтгэх дэд ажлын хэсэг, УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
13. Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих зөвлөл, ГХЯ
14. Монгол улс Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсэг
15. Үндэсний статистикийн хорооны зөвлөл
16. Хилийн боомтын үндэсний зөвлөл, СЯ
17. Монгол улсын татварын орчинд дүн шинжилгээ хийж...зөвлөмж боловсруулах ажлын хэсэг
18. Стандартчиллын үндэсний зөвлөл, СХЗГ
19. Цахилгаан техникийн үндэсний хороо, СХЗГ
20. Чанарын удирдлагын техникийн хороо, СХЗГ
21. Техникийн хяналтын байгууллагын итгэмжлэлийн техникийн дэд хороо, СХЗГ
22. Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх төсөл /Азийн сан/
23. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэгтэй зөвлөл, Монгол улсын засгийн газар



3 БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

24. Си Жи Эф ХХК-ийн Удирдах зөвлөл
25. Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулах хороо
26. Монгол-Японы засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан худалдаа, хөрөнгө оруулалтын 8 дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах ажлын хэсэг, ХХААХҮЯ
27. “Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг 2 жил тутам зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг, ГХЯ
28. Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга төслийн удирдах хороо, БОАЖЯ
29. Банкны тухай хуулийг УИХ-д өргөн мэдүүлэх ажлын хэсэг
30. СЭЗИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн
31. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн
32. Монгол Оросын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан технологийн засгийн газар хоорондын комисс, ГХЯ
33. Монгол Оросын хил худалдаа бүс нутгийн хамтын ажиллагааны дэд комиссын ажлын хэсгийн гишүүн
34. Монгол – Польшийн худалдаа эдийн засгийн комисс
35. Монгол –Латвийн худалдаа эдийн засгийн комисс
36. Монгол- Киргизийн худалдаа эдийн засгийн комисс
37. Монгол-Казакстаны худалдаа эдийн засгийн комисс
38. Монгол-Чехийн худалдаа эдийн засгийн комисс
39. Монгол-Оросын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн
40. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020 хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг, НЗДТГ
41. Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, ЗГХЭГ
42. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэг, ХНХЯ
43. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг, ХНХЯ
44. Зээлийн Батлан Даалтын Сангийн удирдах зөвлөл
45. Зээлийн Батлан Даалтын Сангийн Хяналтын зөвлөлийн дарга
46. Хөгжлийн банкны ТУЗ-ын хараат бус гишүүн
47. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөл, ХХАХҮЯ
48. Монгол улс, БНСУ хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, нөхцлийг судлан, санал, дүгнэлт гаргах судалгааны баг, ГХЯ
49. Хүүхэд хамгааллын бодлого боловсруулах ажлын хэсэг, ГБХЗХГ
50. Хүүхдийн эрх ... хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах судалгааны ажлын хэсэг
51. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээний дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах комисс, БОАЖЯ



3 БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

52. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг, ЭХЯ
53. Хэмжилзүйн зөвлөлийн гишүүн, СХЗГ
54. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг, ХХААХҮЯ
55. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг
56. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсэг
57. “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээл” төслийн удирдах хороо, СЯ
58. “Улаанбаатарт үйлдвэрлэв” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг, НЗДТГ
59. “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг
60. Тендерийн үнэлгээний хорооны гишүүн, ХХААХҮЯ
61. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг, ХЗДХЯ
62. Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрийн ажлын хэсэг, ГХЯ
63. Экспортыг дэмжих төслийн ажлын хэсэг, СЯ
64. Монгол улсад төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах тухай орон тооны бус зөвлөл, ҮХГ
65. Худалдааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг, ХХААХҮЯ
66. Үндэсний Цахим нэг цонхны бизнесийн процессын ажлын хэсэг, МХЕГ
67. Гаалийн тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэг, ГЕГ
68. “Худалдааны газар, түүний үйлчилгээ” стандартыг шинэчлэх ажлын хэсэг, СХЗГ
69. Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах чиглэлээр судалгаа хийж, зураглал гарган ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг, ЗТХЯ
70. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын орон тооны бус гишүүн
71. Шингэрүүлсэн шатдаг хийн хангамжийн норм, дүрэм, стандартын ажлын хэсэг, АМГТГ
72. Газрын тосны бүтээгдэхүүний хуулийн дэд ажлын хэсэг, УУХҮЯ
73. Газрын тосны бүтээгдэхүүний хэвийн хорогдлыг шинэчлэн тогтоох ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, УУХҮЯ
74. Өрсөлдөөний тухай хуулийн ажлын хэсэг, ШӨХТГ
75. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэдэх Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо, ЗГХЭГ


Зөвлөл

МҮХАҮТ-ын дэргэд бизнесийн салбарыг төлөөлсөн 30 зөвлөл ажилладаг.



4 ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төр ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлж төрөл бүрийн арга хэмжээ, үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 2017 онд дотоодын **13** байгууллага, гадаадын худалдааг дэмжих **28** байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.





4 ХАМТЫН АЖИЛЛАГАА



Дотоод хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ

1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар
2. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам
3. Үндэсний хөгжлийн газар
4. Баянгол дүүргийн засаг даргын тамгын газар
5. Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газар
6. Замын-Үүд Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба
7. Багахангай дүүргийн засаг даргын тамгын газар
8. Төв аймгийн засаг даргын тамгын газар
9. Налайх дүүргийн засаг даргын тамгын газар
10. Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар
11. Увс аймгийн засаг даргын тамгын газар
12. Сонгино хайрхан дүүргийн засаг даргын тамгын газар
13. Аялал жуулчлалын холбоо



Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ

1. Хятадын Нин Ся мужийн Худалдааг дэмжих хороо
2. Канад Монголын Худалдааны танхим
3. БНСУ-ын Канвен мужийн Аж Үйлдвэрийн Салбарын хөгжлийг дэмжих агентлаг
4. Эрхүүгийн ХАҮТ болон БНСУ-ын Эва эмэгтэйчүүдийн их сургуулийн инкубатор төв
5. ӨМӨЗО-ны Худалдааг дэмжих хороо
6. 13 дахь удаагийн Монгол, Хятад, Оросын ХАҮТ-уудын нэгдсэн чуулганы үеэр Хятад-Монголын салбар ХАҮТ-ууд 21 хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

5 СУДАЛГАА

1. БИЗНЕСИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Монголын бизнесийн орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ болон орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээнүүд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоог тодорхойлох зорилгоор МҮХАУТ МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран бизнесийн орчны судалгааг үндэсний хэмжээнд явуулсан. Энэхүү судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн 2010 аж ахуйн нэгжийг хамруулсан. Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээг 5 ерөнхий, 12 дэд бүлгийн 88 асуулгаар 1-7 онооны үнэлгээгээр үнэлүүлэхэд **3.03** буюу хангалтгүй гэсэн үр дүн гарсан.

Монголын бизнесийн орчны үнэлгээ, ерөнхий үзүүлэлтүүдээр

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ КОЭФФИЦИЕНТ	БОЛОМЖИТ ДЭЭД УТГА
1.	Дэд бүтэц, технологи	3.43	7
2.	Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа	3.37	7
3.	Эдийн засгийн орчин	2.96	7
4.	Нийгэм, соёл	2.93	7
5.	Засаглал, хууль эрх зүй	2.69	7
	Үнэлгээний дундаж	3.03	



2. МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ, ТАТВАРЫН ОНОВЧЛОЛ

МУ ын татварын системд шинэчлэл хийх үндэс суурийг тавих, татварын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судалгаа, шинжилгээний дэвшилтэт арга, загваруудыг ашиглан хийж дүгнэлт гарган, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилготойгоор МУИС-ийн бизнесийн сургуулийн судлаачдын багтай хамтран хийсэн судалгаа юм.

Судалгааны хүрээнд бодлого боловсруулагчид төсвийн орлого, зарлагын бүтэц татварын оновчлолд судлаачдын санал болгож буй хосолсон загварыг ашиглахыг санал болгон тооцооллын програм хангамжийг ашиглах зааврын хамт гаргасан. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн их байлгах оновчтой бүтцийг тодорхойлон багцын онолын загварыг дэвшүүлсэн.





5 СУДАЛГАА



3. БИЗНЕСИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

Энэ судалгаагаар бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, түүний өөрчлөлтийн талаарх хүлээлт, макро эдийн засгийн үндсэн асуудлуудаар бизнес эрхлэгчид, иргэдийн байр суурь, цаашид яаж өөрчлөгдөх талаар хүлээлтийг тодорхойлдог. Судалгааг санамсаргүй түүврийн аргаар Улаанбаатар хотын 526 хүн, 21 аймаг болон сумын төвүүдийн 336 хүнийг хамруулсан болно. 2012 онд нийт судалгаанд оролцогчдын 13% бизнесийн орчинд "муу" үнэлгээ өгч байсан бол 2016 онд судалгаанд оролцогчдын 43% нь "муу" дүн тавьжээ.

БИЗНЕСИЙН ОРЧНЫ ДҮГНЭЛТ





6 АРГА ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, зах зээлээ өргөжүүлэх хамтын ажиллагаа, хоорондын уялдаа холбоог сайжруулах, салбарын өмнө тулгамдаж буй асуудал болон ололт амжилтын талаар санал бодлоо солилцох гэх мэт олон зорилгын дор 2017 онд нийт 80 гаруй арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 12000 орчим хүнийг хамруулсан байна.

“B2B meeting”

Бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, тодорхой асуудлын талаарх мэдээллийг хуваалцах, санал солилцох чөлөөт индэрийг бий болгох зорилгоор B2B уулзалтуудыг тодорхой сэдвийн хүрээнд **14** удаа зохион байгуулж тухайн асуудал хариуцсан төрийн байгууллагын төлөөлөл, салбарын туршлагатай эрдэмтэн судлаач, мэргэжлийн экспертүүд болон олон улсын бизнес эрхлэгчид гээд нийт давхардсан тоогоор **700** орчим хүмүүсийг хамруулан зохион байгуулсан. Тухайлбал:

1. Инноваци
2. Техник технологийн дэвшил
3. Санал санаачилга шийдэл
4. Экспортыг дэмжих төсөл
5. Хөрөнгө оруулалтыг татах боломж
6. Эрчим хүчний хэмнэлт
7. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд-Шарк танк



“Business breakfast” уулзалт

Бизнес эрхлэгчдийг төртэй холбох, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах зорилгоор “Business breakfast” өглөөний уулзалтыг нийт **10** удаа зохион байгуулсан. Салбарын асуудал эрхэлсэн сайд нар болон эдийн засагч нартай уулзаж санал бодлоо солилцох уг уулзалтанд давхардсан тоогоор **2500** орчим бизнес эрхлэгчдийн дунд амжилттай зохион байгуулсан.

1. МУ-ын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат
2. Зам тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат
3. Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга П.Цагаан
4. УИХ-ын гишүүн Д.Сумъяабазар
5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол
6. Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт
7. МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг
8. Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболд
9. Ерөнхийлөгчид нэр дэвшигч С.Ганбаатар
10. Ерөнхийлөгчид нэр дэвшигч Х.Баттулга



6 АРГА ХЭМЖЭЭ



ТОП-100 аж ахуйн нэгж 2016

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй “ТОП-100” АЖ АХУЙН НЭГЖ-ийг Монгол Улсын Засгийн Газар, МҮХАҮТ хамтран жил бүр өргөмжилдөг уламжлалтай бөгөөд 2015 оноос Сангийн Яам, Татварын Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий Газар, Нийгмийн Даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн 3 дахь жилдээ эрэмбэллээ.



“ENTREPRENEUR-2017”

МҮХАҮТ-аас жил бүр уламжлал болгон тухайн оны онцлох 10 аж ахуйн нэгж, салбарын шилдгүүдийг тодруулдаг "Энтерпренер 2017" шагнал гардуулах ёслолын арга хэмжээ 21 дэх жилдээ амжилттай зохион байгуулсан.



Үндэсний чанарын чуулган

Дэлхийн чанарын өдрийг тохиолдуулан Монгол улсад зохион байгуулдаг Үндэсний чанарын 7 хоногийн хүрээнд Үндэсний чанарын чуулган арга хэмжээг 3 дахь жилдээ зохион байгуулж Үндэсний чанарын шагналын шалгаруулалтыг явууллаа. Үүнд:

1. “Шилдэг үйлчилгээ”-ээр Нью жуулчин турс ХХК-ийн Зочлох үйлчилгээ
2. “Шилдэг бүтээгдэхүүн”-ээр Агь ХХК-ийн Лапша брэнд
3. “Шилдэг байгууллага”-аар Витафит инвест ХХК тус тус шалгарав.

6 АРГА ХЭМЖЭЭ



"CHAMBER BUS" хөтөлбөр

Энэхүү хөтөлбөрт нийт 14 аймгийн 400 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулан тухайн аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй уулзуулж тулгамдаж буй асуудлуудыг танилцуулж шийдвэрлүүлэх, Улаанбаатар хотын томоохон ААН-үүдийн үйл ажиллагаатай танилцуулах, үйлдвэрүүдээр зочлуулах, туршлага судлуулах аяныг зохион байгуулсан.

"ENTERPRENEUR CHALLENGE" хөтөлбөр

Entrepreneur Challenge хөтөлбөрийг 6 аймагт хэрэгжүүлж орон нутгийн 700 гаруй бизнес эрхлэгчид буюу шинээр бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудыг хамруулан тэдгээрийг чадавхижуулах, бизнес эрхлэхэд суурь мэдлэг, чадвар олгох сургалт, семинарыг зохион байгуулахаас гадна олон улсын экспертүүдийн хамт зөвлөгөө, мэдээлэл өгч амжилттай ажилласан.

Бусад арга хэмжээ, уулзалтууд

1. Евразийн уулзалт
2. Эрхүү хотын бизнес эрхлэгчдийн уулзалт
3. Барилгын ханган нийлүүлэгчдийн чуулган
4. Монгол Японы бизнес эрхлэгчдийн уулзалт
5. Лэйди энтрепернер
6. Японы зах зээлд гарах боломж танилцуулга уулзалт
7. Хаягдал ус-Нөөц баялаг форум
8. Бизнес лиг
9. Аялал жуулчлалын чуулган
10. Хуулийн яармаг өдөрлөг
11. Эрүүл хүнс бидний сонголт уулзалт
12. Куба улсын бизнес эрхлэгчдийн уулзалт
13. Интернэт маркетинг конференц
14. Худалдааг хөнгөвчлөх үндэсний семинар
15. Монгол Солонгосын бизнес уулзалт
16. Туркийн бизнес эрхлэгчдийн уулзалт
17. Даян дэлхийн гэрээ уулзалт
18. Чөлөөт бүсийн хууль эрхзүйн орчин уулзалт
19. Монгол Казакстаны бизнес уулзалт
20. Словак улсын бизнес форум
21. Монгол Оросын бизнес уулзалт



7 ҮЗЭСГЭЛЭН

Дотоод үзэсгэлэн

Үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх зорилгоор 10 орчим үзэсгэлэнг төрийн болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.



“Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи-2017”

“Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи-2017” Олон улсын үзэсгэлэн 20 дахь жилдээ зохион байгуулав. Жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, экспортыг дэмжих, дэвшилтэт технологийг танилцуулах зорилгоор зохион байгуулагддаг тус үзэсгэлэнд Монгол улсаас 115, БНАСУ-аас 11, Пакистаны 1, ОХУ-ын 2 жижиг дунд үйлдвэр эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулсан.



“Улаанбаатар түншлэл-2017”

Монгол Улсын Засгийн газраас 2017 оныг “Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн”, МҮХАҮТ-аас “Худалдааг хөнгөвчлөх” жил болгон зарласантай холбогдуулан 2017 оны 9 дүгээр сарын 07-10 хооронд “Улаанбаатар Түншлэл - 2017” Олон улсын үзэсгэлэн яармагийг 42 дахь жилдээ МҮХАҮТ, НЗДТГ хамтран зохион байгуулсан. ОХУ, Чех, Непал, Хонг Конг, Тайван зэрэг орнуудаас 14 компани, дотоодын 100 гаруй аж ахуйн нэгж хувь хүн оролцсон.

Бусад үзэсгэлэн

1. Агаарын бохирдол технологийн үзэсгэлэн
2. Улаанбаатар түншлэл 2017 Олон улсын намрын үзэсгэлэн
3. “SME-2017” үзэсгэлэн
4. “Монголд үйлдвэрлэв-2017” Цагаан сарын үзэсгэлэн
5. “Ворота в Азию” 27 дах удаагийн ОХУ-ын бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн



7 ҮЗЭСГЭЛЭН

Гадаад үзэсгэлэн

Монголын экспортын бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахад дэмжих, сурталчлах зорилгоор БНСУ, Малайз, БНЭУ, БНХАУ-ын хотууд зэрэг нийт 9 олон улсын үзэсгэлэнд давхардсан тоогоор 78 аж ахуйн нэгжүүд хамрагдсан.


1. Торгоны замын ач холбогдол сэдэвт хөрөнгө оруулалтын нэгдсэн форум, үзэсгэлэн, Бээжин хот, 1-р сарын 16-17
2. Олон улсын халал бүтээгдэхүүний үзэсгэлэн, Малайз улсын Куала Лампур хот, 4-р сарын 3-6
3. БНХАУ-ын ӨМӨЗО-ны бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа-2017, 6-р сарын 9-12
4. Монгол Тайванийн эдийн засгийн хамтарсан хуралдаан, 5-р сарын 5
5. Хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн, БНЭУ, 4-р сарын 15-17
6. БНХАУ-ын Ий-Үү хотын шилдэг импорт экспортын барааны үзэсгэлэн, 5-р сарын 6-9
7. Олон улсын импортын бараа бүтээгдэхүүний 24 дэх экспо, Тианжин хот, 5-р сарын 12-16
8. ОУ-ын бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн, Эрээн хот, 6-р сарын 2-12
9. “2017 GTI Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн яармаг”, БНСУ-ын Дунхэ хот, 9-р сарын 21-24



8 СУРГАЛТ

2017 онд Гадаад худалдааны академийн зохион байгуулсан урт болон богино хугацааны сургалтанд нийт 6522 хүнийг хамруулсан байна. Үүнээс 4560 нь богино хугацааны сургалт хамрагдсан байна.

1. Гадаад худалдааны менежерийн сургалт
2. Даргын туслах бэлтгэх сургалт
3. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт
4. Азийн сангийн төслийн хүрээнд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан сургалт
5. Богино болон захиалгат сургалт
6. Талх нарийн боовны сургалт
7. Бизнес ба авлига сэдэвт сургалт





9 ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ


МҮХАҮТ-аас үндсэн 7 бүлэг үйлчилгээг гишүүд ба бизнес эрхлэгчдэд үзүүлсэн бөгөөд 2017 онд явуулсан сэтгэл ханамжийн судалгааны дундаж үнэлгээ 54.7% хувь байна.

Гарал үүслийн гэрчилгээний олголт



Арбитрын үйл ажиллагаа



2017 онд шинээр 71 хэрэг хүлээн авсан бөгөөд нийтдээ 124 хэрэг дээр арбитрын ажиллагаа явуулж 77 хэргийг хянан шийдвэрлэсэн. Арбитрын урьдчилсан болон хэрэг шийдвэрлэх 410 гаруй хуралдаан хийсэн.





9 ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Бусад үйлчилгээний тоо



10 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР



МҮХАҮТ, ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл

ХБНГУ-ын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны яамнаас санхүүжилтээр МҮХАҮТ, ГХАҮТХ хамтран Монголын бараа бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр Архангай аймагт хонины ноос, Увс аймагт чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл 2015.09-2018.8 сарын хооронд 3 жилийн хугацаатай хэрэгжиж байна.



2017 онд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6 дугаар багт Хонь хяргах, угаах жишиг цогц үйлчилгээний төв байгуулсан.



Увс аймаг орон нутгийн дэмжлэг 20 хувь буюу 15 сая төгрөг, ГХАҮТХ-аас 80 хувь буюу 57.3 сая төгрөг, нийт 72 сая 334 мянган төгрөгийн төсөвтэйгээр 1200 гаруй метр газар далан, суваг шуудууны ажил хийгдсэн.



10 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР



Азийн сан, Койка ОУБ, НЗДТГ-тай хамтарсан бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих төсөл

Азийн сан, KOICA, НЗДТГ-тай хамтран “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв” төслийн хүрээнд 2017 онд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

- **Сургалт:** 19 нэр төрлийн сургалтыг 26 удаа зохион байгуулж, 1170 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг хамруулсан.
- **Зөвлөх үйлчилгээ буюу ментор:** 18 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 11 чиглэлээр 216 цагийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- **Уулзалт, хурал:** 4 удаагийн хурал, уулзалтанд 285 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг хамруулав.
- **Туршлага судлах аялал:** БНСУ-руу 2 удаагийн туршлага судлах аялалыг зохион байгуулав. Аялалд НЗДТГ, Зээлийн батлан даалтын сан, БЭЭЗ, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл зэрэг 17 хүнийг хамруулав.



Дэлхийн банкны экспортыг дэмжих төсөл

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (ОУХА)-ын хооронд байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу 14,300,000 Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ)-тэй тэнцэх хөнгөлөлттэй зээлийн төсөл нь уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготой. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд МҮХАҮТ-ын зүгээс мэдээлэл хүргэх, сургалт явуулах, судалгааг хийх чиглэлээр хамтран ажиллаж байна.



10 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Танхимын дотоодод хэрэгжүүлсэн төсөл


Танхимын гишүүдэд, бизнес эрхлэгчдэд үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, гишүүдийн сэтгэл ханамжийг сайжруулах зорилгоор Олон улсын худалдааны төв, Олон улсын худалдааны танхим, Европын холбоо, ХБНГУ болон бусад орнуудын экспертүүдтэй хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.



International
Trade
Centre

МУХАҮТ-ын гүйцэтгэлийн замын зургийг сайжруулах төсөл

2016 онд ОУХТ-өөс хийсэн танхимын үйл ажиллагааны харьцуулсан үнэлгээн дээр тулгуурлан үр дүнд бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, стратегийн зорилтууд-нэгжийн зорилтууд-ажилтны зорилтууд гэсэн гүйцэтгэлийн хэмжигдэхүйц тогтолцоог бүрэн бүрдүүллээ.



Нидерландын ахмад экспертүүдийн холбооны "Дотоод нөөц бололцоогоо ашиглах нь" төсөл

"Inside out 3.0" хөтөлбөрийн хүрээнд ахмад эксперт Фред Дэ Боер танхимын өөрөө удирдлагат багуудыг бий болгон чадавхижуулах, танхимын дунд шатны удирдлагуудын чадавхийг бэхжүүлэх "Мотиваци, харилцааны соёл", "Удирдах ур чадвар" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.



10 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ISO9001 чанарын удирдлагын стандартын тогтолцооны хэрэгжүүлэлт

МҮХАҮТ өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулах, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилгоор чанарын удирдлагын ISO9001:2016 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. 2017 онд танхимын газар нэгжүүдийн үйл явцын 132 тодорхойлолтуудыг боловсруулан гаргасан.

Үйл явцын тодорхойлолтуудыг үйл ажиллагааны чиглэлээр ангилан үйл явцын замын зургийг боловсруулсан.

ҮЙЛ ЯВЦЫН ЗАМЫН ЗУРАГ			
БОДЛОГО	ГИШҮҮНЧЛЭЛ	АРГА ХЭМЖЭЭ	ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦ
12 үйл явц	2 үйл явц	8 үйл явц	12 үйл явц
ХАМТЫН АЖИЛЛАГАА	ҮЙЛЧИЛГЭЭ	СУРГАЛТ	САНХҮҮ
18	31 үйл явц	9 үйл явц	9 үйл явц
		МАРКЕТИНГ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ	ДОТООД ҮЙЛЧИЛГЭЭ
		16 үйл явц	15 үйл явц
			Нийт 132 үйл явц

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим,
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17011, UB Post – 101011001

Утас: +976-11-310619

Факс: +976-11-324620

e-mail: policy@mongolchamber.mn

www.mongolchamber.mn